АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2026 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

№ 04/26

Нисэх буудал, перрон талбайд нисэхийн бус үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж

Нисэх буудлын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдал, хамгаалалтын дэглэмийг алдагдуулахгүйгээр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах зорилгоор мөн холбогдох нэгжүүдийн уялдаа холбоо, хяналт зохион байгуулалтыг онцгой анхаарч ажиллахад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Перрон талбайд зөвхөн зөвшөөрөгдсөн ажилтан, оролцогчдыг нэвтрүүлэх;
2. Нэвтрэх цэгүүдийн хяналт шалгалтыг нэмэгдүүлэн ажиллах;
3. Нисэх буудал түүний орчин, аюулгүйн хамгаалалттай болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд камерын хяналтыг хийх;
4. Дроны нислэгийн бүс, хамгаалалтын бүсийг тодорхой тогтоож, тэмдэгжүүлэх;
5. Агаарын хөлөг, техник хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр бүс тогтоох;
6. Агаарын хөлгийн хөдөлгөөн, газрын үйлчилгээний техник хэрэгслийн хөдөлгөөнтэй уялдуулан үйл ажиллагааг зохион байгуулах;
7. Дроны ажиллагаа нь нисэх буудлын холбоо, навигаци, гэрэлтүүлэг болон нислэгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангах;
8. Онцгой нөхцөл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг нэн даруй зогсоох бэлэн байдлыг хангах;
9. Галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах;
10. Үзүүлбэрийн үеэр нислэгийн хөдөлгөөний удирдлага болон холбогдох нэгжүүдтэй байнгын холбоотой ажиллах;
11. Перрон талбайд FOD (гадаад биетийн хяналт)-ын үзлэгийг тогтмол хийж, хог хаягдлыг тухай бүрд зайлуулах;
12. Нисэх буудлын хамгаалалт, аюулгүй байдлын зааварчилгааг нийт оролцогчдод урьдчилан өгсөн байх;
13. NOTAM мэдээг цаг тухайд нь боловсруулан зарлуулах;
14. Үйл ажиллагаатай холбоотой эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох заавар, журмын дагуу шуурхай мэдээлж ажиллах.

Утас: 976-88974030
Цахим шуудан: sqmd@ncac.mn